



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 22 өдөр

Дугаар

4 / 73

Модот

**Хорио цээрийн дэглэм тогтоох
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22, 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалт, 51 дүгээр зүйл, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.3, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоол, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2025 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 25-3012 тоот шинжилгээний дүнг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Нугаар багийн нутаг “Хавчир ганга” нэртэй газар нутаглаж байгаа малчин Д.Ариунболд-нд УМЭАЦТЛ-ийн 2025 оны 3012 дугаартай шинжилгээний дүнгээр малын гоц халдварт Хонины цэцэг өвчин оношлогдсон тул Мал эмнэлгийн тасгийн саналыг үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2.Гоц халдварт өвчний хорио цээрийн дэглэмийн үеийн бүсүүдийн хилийн заагийг тогтоосон тойм зургийг 1 дүгээр хавсралтаар, дэглэмийн үед ажиллах Мэргэжлийн багийн бүрэлдэхүүнийг Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч (П.Ганчимэг)-ээр ахлуулан 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хорио цээрийн дэглэмийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангуулан хүч хэрэгслийг зөв хуваарилан оролцуулж, голомтын бүсийн заагт тасралтгүй ажиллагаатай хяналтын цэгийн байршлыг тогтоож, сэжигтэй бүсийн заагт хөдөлгөөнт эргүүл ажиллуулан мал, амьтан, хүн, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих зэргээр хорио цээрийн арга хэмжээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар ханган холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжүүлэн ажиллахыг Мэргэжлийн ангийн дарга (Ү.Ичинхорлоо)-д,

4.Хорио цээрийн дэглэмийн үед мал, амьтны гоц халдварт хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврын дагуу мал эмнэлгийн цогц арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, халдварт өвчний цагийн байдлын мэдээллээр холбогдох газруудыг ханган ажиллахыг Мэргэжлийн багийн ахлагч, (П.Ганчимэг)-д,

5.Хорио цээрийн дэглэм тогтоосон бүс нутагт зайлшгүй шаардлагаар нэвтрэх хүн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс бусад шилжилт хөдөлгөөнийг бүрэн зогсоож, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хорио цээрийн дэглэм сахиулах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг сумын Цагдаагийн хэсгийн төлөөлөгч (Б.Хангай)-д,

6.Мэргэжлийн анги, багийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа ажилтан, албан хаагч, хорио цээрийн бүс дэх малчид, иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхийг сумын Эрүүл мэндийн төв (Н.Очирмаа)-д,

7.Хорио цээрийн бүс дэх малчин өрх, мал бүхий иргэдэд малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон өвчний хор хөнөөлийн талаар ухуулан ойлгуулах, мал сүргээ хариулгатай байлгах, малчдын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, Сумын Онцгой комиссын шийдвэрийн талаар мэдээлэл хүргэх ажлыг багийн Засаг дарга нар (У.Гантулга, Б.Чулуунцэцэг, Д.Мягмарсүрэн, О.Тунгалагмөрөн нар)-т,

8.Малчин өрх, мал бүхий иргэд, малын тоо, толгой болон холбогдох судалгаа, хязгаарлалтын дэглэмийн бүс дэх малчин өрх, хот айлын байршлын зургийг гарган сумын Онцгой комисс, Мэргэжлийн багд танилцуулахыг сумын Багийн Засаг дарга (Б.Чулуунцэцэг)-т,

9.Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг бүх шатанд эрчимжүүлж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Онцгой комисс (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

10.Хорио цээрийн дэглэм тогтоосон бүсэд ажиллах мэргэжлийн анги, багийн албан хаагчдын хоол, унааны болон шаардагдах бусад зардлын тооцоог гарган, зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Б.Буяндэлгэр)-т зөвшөөрсүгэй.

11.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б.Ганзориг)-т даалгасугай.

12.Захирамж батлагдсантай холбогдуулан сумын Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн А/69 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ